



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан  
“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн  
тусгай зөвшөөрлийн түр журам”-д нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг  
үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр  
тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай  
зөвшөөрлийн түр журам”-д дор дурдсан агуулгатай дараах 7 дугаар зүйлийн 7.7, 7.8, 7.9 дэх  
хэсгүүдийг тус тус нэмсүгэй:

**1/ 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг:**

“7.7. ХААБ нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос ажлын 30 хоногийн өмнө  
тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт болон дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд  
ирүүлнэ:

7.7.1. хүсэлт бүхий албан бичиг;

7.7.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тэмдэглэл;

7.7.3. жилийн эцсийн санхүүгийн тайлан;

7.7.4. тухайн жилийн арилжааны мэдээ, тайлан;

7.7.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт;

7.7.6. бусад.”

**2/ 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг:**

“7.8. Энэ журмын 7.7-д заасан хугацаанд баримт бичгээ Хороонд ирүүлээгүй нь тусгай  
зөвшөөрлийг сунгахгүй байх, түдгэлзүүлэх үндэслэл болно.”

**3/ 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг:**

“7.9. Тусгай зөвшөөрлийг сунгахыг зөвшөөрсөн Хорооны тогтоолыг үндэслэн тусгай  
зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ.”

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийг сунгах  
зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.

3. Журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд  
даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000064